


2019 ОНЫ УРСГАЛ ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АСФАЛТ  
ЗАМ ЗАСВАРЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

№	Материалын нэр	Нэгж	Тоо хэмжээ	Ажлын даалгавар
1	Асфальт зам	м2	186,67	Дулааны шугамын засвартай уялдуулж засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.
<b>ДҮН</b>			<b>186,67</b>	

Тайлбар: Техникийн тодорхойлолтыг хавсаргав.

Хянасан: ДСАЗУАлбаны дарга  Ж.Батмөнх

ДСАЗУАлбаны ахлах инженер М.Мөнхтөр

Техникийн тодорхойлолт  
бичсэн: ДСАЗУАлбаны инженер  З.Энхболд

## Материал

### 4.1 Монголын авто замын нөхцөлд тохирсон битумыг сайжруулагч нэмэлт

4.1.1 Монголын авто замын нөхцөлд тохирсон битумыг сайжруулагч нэмэлт нь асфальт хольцын хүйтнээс үүсэх хагаралыг эсэргүүцэх чадварыг дээшлүүлж нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг багасгах давуу талтай бөгөөд битумтай урьдчилан хольж хэрэглэх боломжтой.

4.1.2. Монголын авто замын нөхцөлд тохирсон сайжруулсан нэмэлт бүхий битумын чанар нь хүснэгт 2.1 ийн шаардлагыг хангана. Нэмэлтийг нийлүүлэх үед үйлдвэрлэгч хүснэгт 2.1 д заасан чанарын туршилтын үр дүнг танилцуулна.

Битумыг сайжруулагч нэмэлт болон битумын чанарын шаардлага

хүснэгт 2.1

Ангилал	Сайжруулсан битум
Нэмэлт бодисыг битумтай хольсны да раа ажиллах хэм	+64°C -34°C
Нэмэлтийн хувь (битумын эзлэх хувийн)	*
Холих температур (°C)	130 - 160
Нягтруулах температур (°C)	110-140

Тайлбар: \* Нэмэлтийн орцыг, битумын шинж чанараас хамаарч сонгоно. Монголын авто замын нөхцөлд тохирсон битумыг сайжруулагч нэмэлт болон битумыг үйлдвэрлэгч нь дараахь нөхцлийг зайлшгүй тайлагнана.

- ① Бүтээгдэхүүний нэр
- ② Нэмэлтийн хувь
- ③ Орцоор тогтоосон холих температур
- ④ Орцоор тогтоосон нягтруулах температур
- ⑤ Нягт

### 4.2 Дүүргэгч материал:

4.2.1 Дайрга, буталсан хайрга ба угаасан элс зэрэг дүүргэгч нь чанарын үзүүлэлтээрээ доор дурьдсан техникийн шаардлагуудад нийцсэн байх шаардлагатай.

4.2.1.1 Том дүүргэгч: D692 Битумэн хольцод хэрэглэх том дүүргэгчид тавигдах техникийн шаардлага

4.2.1.2 Жижиг дүүргэгч: D1073 Битумэн хольцод хэрэглэх жижиг дүүргэгчид тавигдах техникийн шаардлага

4.2.1.3. Том болон жижиг ширхэгтэй чулуу нь бат бэх, эдэлгээ сайтай байх бөгөөд Монголын чулуун материалын техникийн шаардлага болон /хүснэгт 2.2/ - ын чанарын шаардлагыг хангасан байна.

4.2.1.4. Том болон жижиг ширхэгтэй чулуу, эрдэс нунтагтай хольсон чулуу нь асфальтбетон хольцын нийлбэр ширхэглэлийн шаардлагыг хангасан байх шаардлагатай

## Чулууны чанарын шаардлага

Ангилал		Туршилт хийх арга	Техникийн шаардлага
Жижиг ширхэгтэй чулуу	Элсний эквивалент	MNS ASTM D 2419:2005	50 доош
	Жижиг ширхэгтэй чулууны ширхэглэлийн бүрэлдэхүүн тодорхойлох	MNS AASTHO M 43:2002	
Том ширхэгтэй чулуу	Элэгдэл (%)	MNS ASTM C535:2003	25 бага
	Бат бэх (натри сульфатыг ашигласан (%))	MNS ASTM C 88:2008	12 бага
	Чулуу битумтэй барьцалдах чадвар (%)	MNS AASHTO T 182:2002	98 дээш
	Ус шингээлт (%)		2.0 дээш
	Нягт (%)	MNS AASHTO T 166:2004	2.3 дээш
	Үзүүрлэг ба хавтгай хэсгийн индекс (%)	MNS BS 812	30 дээш

4.2.2 Эрдэс нунтаг нь MNS 4904-1:2000 стандартын техникийн шаардлагыг хангавал зохино.

4.2.2.1 Эрдэс нунтаг нь Монголд мөрдөгдөж буй эрдэс нунтагийн техникийн шаардлагыг хангах ба чийгийн агууламж 1% -иас доош үед бөөм үүсэхгүй байх бөгөөд /хүснэгт 2.3/- ын шаардлагыг хангавал зохино.

#### Эрдэс нунтагийн ширхэглэл

Хүснэгт 2.3

Шигшүүрийн хэмжээ (мм)	Шигшүүрээр өнгөрөх хувь (%)
0.600	100
0.300	95-100
0.075	70-100

#### 4.3. Битум:

4.3.1 Битум нь Монголд хэрэглэж буй битумын техникийн шаардлагыг хангавал зохино. Тайлбар: Битумын төрөл ба ангилалын сонголт хийхдээ MNS ASTM D2399:2004, MNS ASTM D3628:2004 аргачлалуудыг удирдлага болгоно.

4.3.2 Ашиглах үеийн битум нь MNS ASTM D2399:2004 техникийн шаардлагад нийцсэн байна.

4.3.3 Ашиглах үеийн битумын эмульс нь MNS ASTM D977:2004 буюу техникийн шаардлагад нийцсэн байна.

Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар
2. Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажуулсан санхүү байдлын тайлан
3. Гэрээг хэрэгжүүлэх удирдах техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаар мэдээлэл
4. Сүүлийн 2 жилд хийсэн зам барилгын ажлын нийт мөнгөн дүнг жилээр харуулсан жагсаалт
5. Ижил төстэй ажлын хийж гүйцэтгэсэн туршлага, одоо хэрэгжиж буй гэрээний тухай мэдээлэл
6. Гэрээг гүйцэтгэхэд шаардагдах зайлшгүй шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалт
7. Гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотлох баримт бичиг /зээл авах баталгаажсан эрх/
8. Захиалагч харилцагч банкнаас нь тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл

Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадварын шалгуур үзүүлэлт

1. Сүүлийн 2 жилд гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь 1 тэрбум төгрөгөөс багагүй байна.
2. Сүүлийн 2 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага 3-аас багагүй нийт ажлын 70 хувиас багагүй байна.
3. Үндсэн тоног төхөөрөмж, машин механизмыг цаг хугацаанд нь бэлэн байлгах санал  
Ще?%,\_Гэрээнд заасан ажилтай төрөл, дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлага бүхий ерөнхий инженертэй байх /Ерөнхий инженерийн ажлын туршлага 10 жилээс дээш байх/
4. Гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь гэрээт ажлын 90 хувиас багагүй байна.
5. Сүүлийн 2 жилийн хугацаанд ашигтай ажилласан байх